

**ДӨРВӨН ОЙРАДЫН ХООРОНДОХ ЭРХ МЭДЛИЙН ӨРСӨЛДӨӨН БА
УЛС ТӨРИЙН УДИРДАГЧДЫН ӨӨРЧЛӨЛТ**

Шим, Хосунг *

Зүүнгарын хаант улс монгол үндэстний байгуулсан дэлхийн хамгийн сүүлчийн нүүдлийн эзэнт гүрэн байснаараа их алдартай юм. 1758 онд Манж-Чин улс Зүүнгарын хаант улсыг мөхөөн сүйтгэсэний дараа ямар нэгэн нүүдэлчдийн хүчтэй тусгаар тогтносон улс, эзэнт гүрэн байгуулагдаагүй юм. Түүнээс хойш ихэнх нүүдэлчид Манж-Чин улс эсвэл Оросын цагаан хааны дэглэмийн доор орох болсон юм.

Зүүнгарын хаант улсын түүх хэд хэдэн талаараа их чухал. Юуны түрүүнд, Зүүнгарын хаант улсын түүх бидэнд нүүдэлчин эзэнт улсын тухай янз бүрийн дэлгэрэнгүй, ховор нандин мэдээллийгөгч чадна. Яагаад гэвэл, Зүүнгарын хаант улсын тухай түүхэн эх сурвалж нь өөр нүүдэлчин улсуудынхаас харьцангуй элбэг арвин. Тийм учраас Зүүнгарын хаант улсын түүх нь нүүдэлчин гүрний улс төр, эдийн засаг, захиргааны бүтэц, нийгэм, аж ахуй гэх мэт олон зүйлийн тухай илүү тодорхой үзэл санааг үүсгэх болно. Гэхдээ, харамсалтай нь, Зүүнгарын хаант улсын түүх нь хамгийн бага судласан түүхэн сэдвүүдийн нэг бөгөөд үүний тухай олон буруу үзэл баримтлал байна.

Зүүнгарын хаант улсын тухай хамгийн дэлгэрсэн буруу утга санаа бол Зүүнгарын хаант улс гэдэг нэр. Олон эрдэмтэд Зүүнгарын хаант улсыг угаасаа байсаар байсан ба угаасаа хүчтэй улс байсан гэж бодоод бүх Ойрад хүмүүсийн түүхийг зөвхөн Зүүнгарт л төвлөрүүлэн тайлбарлаж ирсэн. Тухайлбал, олон түүхчид Зүүнгарын хаант улс гэдгийг бараг дандаа бүх Ойрад хүмүүсийг засаглаж байсан гэж бичсэн байдаг. Гэхдээ, Мияваки Жүнко гэдэг Япон эрдэмтний бичсэн өгүүллээр, түүхэнд Зүүнгарын хаант улс гэдэг эзэнт гүрэн байхгүй байжээ. Үнэндээ, Зүүнгарын хаант улс гэдэг нь Зүүнгар хүмүүсийн удирддаг байсан Дөрвөн Ойрадын холбоо байжээ.¹ Өөрөөр хэлбэл, Зүүнгар хүмүүс уг нь Дөрвөн Ойрадын хүмүүсийн дотор байсан нэг бүлэг хүмүүс бөгөөд тэд Дөрвөн Ойрадыг бүгдийг нь засаглаж байгаагүй.²

Тийм болохоор, Зүүнгар хүмүүс болон Зүүнгар улсын түүхийг зөв ойлгохын тулд эхлээд Дөрвөн Ойрадын холбооны түүхийг анхааралтай авч үзэх хэрэгтэй. Дөрвөн

* Shim Hosung, Индианагийн Их Сургуулийн Төв Европ, Азийн судалгааны тэнхим

¹) Hidehiro Okada and Junko Miyawaki-Okada, "The Biography of Zaya Pandita, the Greatest Oirad Monk," *Biographies of Eminent Mongol Buddhists*, ed. Johan Elverskog, International Institute for Tibetan and Buddhist Studies (2008), pp. 37-38.

²) Hidehiro Okada and Junko Miyawaki, "The Biography of Zaya Pandita", p. 36.

Ойрадын холбооны түүхийг шинжлэн судлаад бид Зүүнгар улсыгхэрхэн яаж хүчтэй болсон тухай болон Зүүнгар улсын хөгжиж байсан үед дотоодод нь улс төрийн ямар тэмцэл хөдөлгөөнүүд гарч байсан зэрэг асуултанд хариулж чадах болно. Дөрвөн Ойрадын түүхийн тухай янз бүрийн хэлээр бичсэн түүхэн эх сурвалж байдаг. Ялангуяа, Дөрвөн Ойрадын болон Зүүнгар улсын тухай зөв тэнцвэртэй ойлголт авахын тулд Монгол, Манж, Хятад, Перс, Цагаадай, Орос зэрэг янз бүрийн хэлээр бичсэн түүхэн эх сурвалжуудыг уншиж судлах хэрэгтэй. Гэхдээ, энэ өгүүлэл бол миний ирээдүйн диссертацид зориулж урьдчилсан тойм байдлаар бичсэн бүтээл болохоор, би энэ удаад Дөрвөн Ойрадын түүхийн тухай хамгийн гол үндсэн сурвалж болох *Зая Бандидын Намтар* (*Rab 'byam za-ya pandhidiyin sarayin gerel kemēkü tiiūzi*)³ дээр үндэслэн Дөрвөн Ойрад болон Зүүнгар улсын түүхийг ярина.

1. Дөрвөн Ойрадын Холбооны улс төрийн газарзүй

Зая Бандидын Намтарт өгүүлсэн Дөрвөн Ойрадын түүхийг сайн ойлгохын тулд эхлээд *Зая Бандидын Намтарт* байгаа газрын нэрс болон Дөрвөн Ойрадын нутгийн газарзүйг мэдэж авах хэрэгтэй. Яагаад гэвэл, хэрвээ тус орны газарзүйг тодорхой мэдэхгүй бол, тухайн үед тухайн газар нутаг дээр чухам ямар ямар үйл явдал болсон, тус үйл явдал ямар түүхэн утга учир, ач холбогдолтой байсан бэ гэх мэт асуултанд зөв хариулж чадахгүй. *Зая Бандидын Намтар* бидэнд газарзүйтэй холбоотой гурван төрлийн чухал мэдээллийг өгч байна. Нэгд, тэр намтарт Дөрвөн Ойрадын нутгийн янз бүрийн газар усны нэрсийг дурдсан байдаг. Тус намтар доторх олон уул, гол, нутаг усны нэрс нь ялангуяа өөр хэлээр бичсэн түүхэн сурвалжуудыг уншиж ойлгоход их чухал юм. Мөн түүнчлэн энэ бүтээлээс *Зая Бандидын Бурхан шашны хүрээ* ямар ямар газруудад зусаж, өвөлжиж байсан тухай дэлгэрэнгүй мэдээ сэлтийг мэдэж авч болно. Эцэст нь, хамгийн ач холбогдолтой зүйл нь, энэ *Зая Бандидын Намтар* нь Дөрвөн Ойрадын улс төрийн удирдагчдын, өөрөөр хэлбэл Ойрадын тайж, тайш нарын болон отор нутгийн нэрсийг өгүүлдэг. Хамгийн сүүлд дурдаж байгаа энэ мэдээлэл нь миний өгүүллйн зорилгод хамгийн чухал юм.

Доорх хүснэгтэд байгаа зүйл бол *Зая Бандидын Намтарт* дурдсан Ойрадын тайж, тайш нарын нутгийн зуслан, өвөлжөөний газрын нэрс.

< Хуваарь 1: Хошууд Очирт Тайж буюу Очир Сэцэн Хааны отор нутаг >

Он	Зуслан	Өвөлжөө	Эх сурвалж (Чиндай; Намтар)
1639		Tarbayta-yin харбаяа(n)	p. 5; fol. 3-b [p. 4]
1642		Buγaš	p. 6; fol. 5-a [p. 5]
1644	Lebši-yin хара tal	Biči/Biyi	p. 7; fol. 5-a/b [p. 5]
1646		Ili-yin talγar	p. 9; fol. 7-a [p. 6]
1648	Tarbaytai-yin ulān burā (улирал тодорхойгүй)		p. 10; fol. 8-a [p. 7]
1650	Gurban xusut/Küürge-yin γöl		p. 11; fol. 8-b [p. 7]

³⁾ *Biography of Caya Pandita in Oirat Characters*, Corpus Scriptorum Mongolorum, Institutii Linguae et Litterarum Academiae Scientiarum Reipublicae Mongolicae, Tomus V, Fasciculus 2-3, Ulanbator, 1967, pp. 3-31 (хожим нь, Намтар); 中国社会科学院边疆史地研究中心编, 『清代蒙古高僧传译辑: 中国边疆史地资料丛刊蒙古卷』, 北京: 全国图书馆文献缩微复制中心, 1990, pp. 3-86 (хожим нь, Чиндай).

1652		Xara tal	p. 29; fol. 15-a [p. 11]
1658	Asu		p. 34; fol. 19-a [p. 14]
1659	Asu		p. 34; fol. 19-b [p. 14]
1660	Zuyi		p. 35; fol. 20-a [p. 14]
1661		Їауан хууиг (намар?)	p. 37; fol. 22-b [p. 16]
1662	Talyar (хавар)		p.38; fol. 23-a [p. 16]
1671	Хахунайцауан ноур		p. 47; fol. 34-b [p. 23]
1675		Emil-yin xara b6r6q	p. 47; fol. 34-b [p. 23]

<Хуваарь 2: Хошууд Авлайгийн отор нутаг>

Он	Зуслан	Өвөлжөө	Эх сурвалж (Чиндай; Намтар)
1639	Bulana-yin usan хууиг		p. 5; fol. 3-b [p. 4]
1646		Їара тохой	p. 9; fol. 7-a [p. 6]
1647		Zuyi	p. 10; fol. 7-b [p. 7]
1653		T6m6r 6or6o	p. 29; fol. 16-a [p. 12]
1654	Bulana-yin usun хууиг		p. 31; fol. 16-b [p. 12]
1657		Beške/B6k6ni yol	p. 33; fol. 18-b [p. 13]
1658		Їара тохой	p. 34; fol. 19-b [p. 14]
1659		Їара тохой	p. 34; fol. 19-b [p. 14]
1660		Ayiyuш-iyin 6ayan тохой, Alxuyi, Alax6-yin yaш6uni t6ur6i uluxun	p. 35; fol. 20-a [p. 14]
1661	Er6is	B6k6ni yol	p. 36; fol. 21-a [p. 15]
1662	Xarbayа (хавар)		p. 37; fol. 22-b [p. 16]

<Хуваарь 3: Хошууд Галдамбагийн отор нутаг>

Он	Зуслан	Өвөлжөө	Эх сурвалж (Чиндай; Намтар)
1654	Kok6 usun, xara tala		p. 31; fol. 16-b [p. 12]
1658		Talas-ын хил	p. 33; fol. 19-a [p. 13]
1662	Їui Talas (хавар)		p.38; fol. 23-a [p. 16]

Дээрх мэдээллийн дагуу, бид Хошуудын гол тайж, тайш нарын газар нутгийг ойролцоогоор мэдэж авч чадна. Зая Бандидын Намтарт бичсэнээр Очирт Тайж, ирээдүйн Очир Сэцэн Хаан Хошуудын болон бүх Ойрад хүмүүсийн дунд хамгийн том газар нутагтай нь байжээ. Түүний нутаг бол хойд талаараа Зайсан нуурын эргэн тойрноос өмнөд талаараа Чу мөрөн хүртэл өргөн уудам газар нутгийг хамарч байсан бөгөөд зүүн талаараа өнөөдрийн Гулжагийн орчимоос баруун тийшээ Балхаш нуурын зүүн эрэг хүртэл үргэлжилж байжээ (Хуваарь 1). Өөрөөр хэлбэл, Очирт Тайж тэр үед

өнөөдрийн Казахстаны зүүн талын бэлчээрийн ихэнхийг эзэмшиж байсан байна. Дараа нь, Очирт Тайжийн өөр ээжтэй дүү болон түүний гол өрсөлдөгч байсан Авлай ч өргөн уудам газар нутгийг хянаж байсан байна. Түүний эзэмшил нутаг нь Балхаш нуурын зүүн-хойд эргээс эхэлж Зайсан нуур ба Эрчис мөрнийг өнгөрөн Алтай нуруунд хүрдэг байв (Хуваарь 2). Товчилж хэлбэл, Авлай Тайжийн эзэмшил нутаг нь Очирт Тайжийн эзэмшил нутгийн зүүн хойд талд байсан бөгөөд бараг Очирт Тайжийн газар нутаг шиг уудам байжээ. Гуравдугаарт нь, Очирт Тайжийн хоёрдахь хүү Галдамбагийн эзэмшил нутаг нь Талас мөрнөөс эхэлж Чу мөрнөөр дайрч өнгөрөөд Балхаш нуурын өмнөд эрэг хүртэл үргэлжлэн оршиж байжээ (Хуваарь 3). Өөрөөр хэлбэл, Галдамба аавынхаа эзэмшил нутгийн баруун хэсгийг захирч байжээ. Эцэст нь, Очирт Тайжийн хамгийн том хүү Дархан Эрдэнэ Хун Тайж аавынхаа эзэмшил нутгийн зүүн талд Богдо болон Эрээн Хавиргыг захирч байж.⁴ Дээрх мэдээллээс, бид Очирт Тайжийг хоёр хүүгийнхээ хамт Дөрвөн Ойрадын газар нутгийн хамгийн баян, хамгийн өргөн уудам хэсгийг эзэмшдэг байсныг баталж чадна.

Дараа нь, Оросын эзэнт улсын элчийн тайланд өгүүлснээр Зүүнгарыг удирдаж байсан Баатар Хун Тайжийн гол үндсэн нутаг нь Эмил гол болон Ховог-сайрын орчим байжээ.⁵ Үүнээс гадна, Баатар Хун Тайжийн үед Зүүнгар нь Хошуудтай Дөрвөн Ойрадыг хамтран хянаж байсан юм шиг байна. Яагаад гэвэл, *Зая Бандидын Намтарт* Баатар Хун Тайж, Очирт Тайж хоёрыг цуг “Ойрадын хоёр тайж (*Oyirodoi xoyor tayiji*)”⁶ гэж нэрлэж байна. Мөн түүнчлэн Баатар Хун Тайжийн хүү Сэнгэ нь Ойрадын нутгийн хамгийн баруун хэсэг Чу мөрний орчимд гэрлэн хурим хийжээ.⁷ Энэ жишээ нь Баатар Хун Тайжийн үеийн Зүүнгар улсыг Хошуудтай хамт Дөрвөн Ойрадын нутагт хүчтэй эрх мэдэлтэй байсныг гэрчилж байна.

Гэхдээ, Баатар Хун Тайжийг өөд болсны дараа Зүүнгар улсын дотор үе залгамжлах тэмцэл болоод Зүүнгар өөрийнхөө эрх мэдлийг удалгүй алджээ. Энэ үйл явдал нь *Зая Бандидын Намтарт* сайн харагдаж байна. Тухайлбал, Баатар Хун Тайжийн үед Зүүнгар нь тус намтар дотор зөндөө тэмдэглэгдсэн боловч, Баатар Хун Тайжийг нас барсны дараа Зүүнгар улсын тухай мэдээ нь уг намтарт бараг алга болжээ. Тэгээд, Сэнгийг дахин Зүүнгар улсыг нэгтгэсэний дараа Зүүнгар гэдэг нэр энэ намтарт дахиад гарч ирж байна. Үүнээс, Баатар Хун Тайжийн үед Хошууд тайцуг Дөрвөн Ойрадын холбоог хамтран удирдах үүрэг гүйцэтгэж байсан Зүүнгар улс нь Баатар Хун Тайжийг нас барсны дараа өмнөх эрх хүч, эрх мэдлээ алдаж, Баатар Хун Тайжийн том хүү Сэнгэ Зүүнгар улсыг дахин нэгтгэхэд алдсан эрх мэдлээ буцаан авсныг мэдэж болно. Сэнгийг Зүүнгар улсыг дахин нэгтгэсэний дараа, Зүүнгарын газар нутаг нь Сэнгийн гол отор газар байсан Өсүг ба Саамалаас⁸ Эрчис мөрөн хүртэл үргэлжлэн оршиж байсан бололтой.⁹

Үүнээс гадна, Галдан Бошигтыг хаан ширээнд сууснаас хойш, *Зая Бандидын Намтар* түүний отор нутгийг дэлгэрэнгүй бичиж эхлэнэ. Дараахан нь Галдангийн отор нутгийн жагсаалт байна.

⁴ Чиндай, р. 38; Намтар, fol. 23-a [р. 16].

⁵ 宮脇淳子, 『最後の遊牧帝國: ジュンガル部の興亡』, 東京: 講談社, 1995, p. 192.

⁶ Чиндай, pp. 5-10; Намтар, fol. 4-b [р. 4], fol. 6-a [р. 6], fol. 7-a [р. 6], fol. 7-b [р. 6].

⁷ Чиндай, р. 10; Намтар, fol. 7-b [р. 6].

⁸ Чиндай, р. 38; Намтар, fol. 23-a [р. 16].

⁹ Чиндай, р. 46; Намтар, fol. 34-a [р. 23].

< Хуваарь 4: Зүүнгар улсын Галдан Бошигт хааны улирлын нутгийн байрлал >

Он	Зун	Өвөл	Эх сурвалж (Чиндай; Намтар)
1671		Erčis	p. 47; fol. 34-b [p. 23]
1676		Erčis	p. 51; fol. 38-b [p. 25]
1676		Šara bel	p. 51; fol. 39-a [p. 25]
1677	Пи-yin хавсарга (хавар), Čayān xüjir (зун)	Erčis	p.51; fol. 39-a [p. 25]
1678	Gürban tulayatu		p.51; fol. 39-a [p. 25]
1679		Erčis	p.52; fol. 39-a [p. 25]
1680	Kükü хуяа	Boro tal	p.52; fol. 39-a [p. 25]
1681		Boro tal	p.52; fol. 39-a [p. 25]
1682		Pi	p.52; fol. 39-b [p. 26]
1686		Boro tal	p.52; fol. 39-b [p. 26]
1687		Erčis	p.52; fol. 39-b [p. 26] p.55; fol. 42-a [p. 27]
1688		Xobdü	p.55; fol. 42-b [p. 28]
1689	Tes (хавар)	Erčis	p.52; fol. 39-b [p. 26] p.56; fol. 43-a [p. 28]
1690		Gunan (намтар ?)	p. 59; fol. 46-b [p. 30]

Энэ хуваариас үзвэл, Галдан Бошигт Хааны гол газар нутаг нь Эрчис мөрөн, Эмил гол хоёрын хооронд байжээ. Хэдийгээр Галдан 1676, 1680, 1681, 1682 ба 1686 онд Шар бэл, Бор тал болон Или гэдэг газар өвөлжсөн боловч, эдгээр нь жирийн тохиолдол байгаагүй. Яагаад гэвэл, Галдан Бошигт Хаан тэр үедээ төв Азид дайн хийхээр Шар бэл гэх мэт газар түр нутаглаж байсан юм. Энгийн үедээ Галдан ер нь Эрчис мөрөн, Эмил гол хоёрын хоорондох нутагт амьдарч байжээ. Галданг Очир Сэцэн хааныг ялаад түүний Илийн бэлчээр дэх нутгийг эзлэн авсаны дараа ч, энэ байдал өөрчлөгдөөгүй. Тийм болохоор, Зүүнгар улсын гол үндсэн газар нутаг бол Эрчис мөрөн, Эмил гол хоёрын хоорондох газар нутаг байв.

Одоо Дөрвөдийн газар нутгийн тухай үзье. Харамсалтай нь, *Зая Бандидын Намтар* Дөрвөдийн нутгийн тухай тодорхой мэдээлэл өгөхгүй байна. Гэвч, Зая Бандидын Торгуудын нутгаар явж ирсэн аяллыг нарийн уншвал, Дөрвөд улсын байрлалыг ойролцоогоор мэдэж болно. Зая Бандид 1654-аас 1666 оны хугацаанд Торгуудын нутгаар аялжээ. Тэрээр Зайсан нуурын баруун талд байсан Бухаш гэдэг газраас гараад, Жайг мөрний сав нутагт байсан Торгууд улс руу явжээ. Эхлээд, Зая Бандид замдаа Гиш-гив, Цагаан, Цэцэн Тайж гэдэг хүмүүст уригдаад, тэр газруудаар орсон байна. Тэдгээр хүмүүс бол Дөрвөдийн захирагч байсан Далай Тайшийн ач хөвгүүд.¹⁰ Тэгээд, Зая Бандид 1655 оны хавар Дөрвөдийн Далай Тайшийн сая нас барсан хүү Гомбо ноёны оршуулгыг удирдсан.¹¹ Дараа нь, Далай Тайшийн ач хөвгүүд Тойн Омбу, Аюуш ноён болон Алдар Тайж¹² нь Зая Бандидыг залсан учраас Зая Бандид тэдэн дээр очсон.

¹⁰⁾ Чиндай, р. 77 зүүлт 115-117.

¹¹⁾ Чиндай, р. 31, р. 77 зүүлт 118; Намтар, fol. 17-a [p. 12].

¹²⁾ Чиндай, р. 32; Намтар, fol. 17-a [p. 12]; Чиндай, pp. 77-78 зүүлт 119-121.

Тэгээд, Зая Бандид Торгуудын нутгаар орсон. Зая Бандидын энэ аяллаас, Дөрвөдийн газар нутаг нь Зайсан нуурын баруун эрэг дэх Бухаш, Жайг мөрний зүүн тал дахь Торгуудын нутаг хоёрын хооронд байсныг мэдэж болно. Үүнээс гадна, *Зая Бандидын Намтарт* бичсний дагуу, Зая Бандид Торгууд улсаас буцаж ирэх замдаа Хар Хум гэдэг газраар оржээ.¹³ Тус газар нь Балхаш нуурын хойд талд оршдог Дөрвөд Тойны нутаг байжээ.¹⁴ Тийм болохоор, Авлайгийн газар нутаг нь тэр үед Балхаш нуурийн зүүн булан дахь Айгуш хүртэл үргэлжилж байсан учраас, Дөрвөдийн газар нутаг нь Балхаш нуурын хойд эргийг дагаад Жайг мөрний зүүн талд байрлаж байсан Торгуудын газар нутагт хүрдэг байсан гэж баталж болно.

Эцэст нь Хойд хүмүүсийн газар нутаг нь бусад Дөрвөн Ойрадынхаас хамгийн бага нь байжээ. *Зая Бандидын Намтарт* бичсэнээр, тэдний нутаг нь Жултус болон Хайду гол, Илийн хөндийн зүүн буланд байжээ.

17-р зууны үеийн Дөрвөн Ойрадын газар нутгийг дараахь байдлаар тоймлож болно: Очирт Тайж ба Авлайгийн удирдсан Хошууд нь Дөрвөн Ойрадын дунд хамгийн чухал, хамгийн өргөн уудам нутагтай байжээ. Тэгээд, Зүүнгар Хошуудын зүүн талд, Дөрвөд Хошуудын баруун талд оршдог байж. Эцэст нь, Хойд Дөрвөн Ойрадын газар нутгийн хамгийн зүүн буланд зөвхөн жижигхэн тал нутагтай байсан бөгөөд Торгуудууд нэлээд хол Ижил мөрөн болон Жайг мөрний эргэн тойронд нутагладаг байжээ. Энэ улс төрийн газрын зургаас, их сонирхолтой зарим түүхэн үнэнийг мэдэж авч болно. Нэгдүгээрт нь, 17-аар зууны үед Ойрадын улсуудын дунд, улс төрийн хувьд чухал нь бол Хошууд, Зүүнгар болон Дөрвөдүүд байжээ. Яагаад гэвэл, Ойрадын газар нутаг дээр болсон улс төрийн үндсэн үйл явдал нь эдгээр гурван улсад төвлөрөн явагдаж байв. Мөн түүнчлэн Ойрадын улс төр дээр чухал үүрэг гүйцэтгэхэд Хойд нь хэтэрхий бага байсан бөгөөд Торгуудууд дэндүү хол байсан байна. Дараа нь, Японы түүхч эрдэмтэн Мияваки Жүнко Зүүнгар гэдгийг уг нь Дөрвөд улсын зүүнгар байсан гэж үзсэн боловч, манай дээрх улс төрийн газрын зургийг нарийн үзвэл, Зүүнгар гэдэг улс нь Дөрвөдийн зүүнгар биш, бүх Ойрадын зүүнгар эсвэл Хошуудын зүүнгар байсан нь харагдана. Эцэст нь, 17-аар зууны үед Дөрвөн Ойрадын улс төрийн удирдагч нь Зүүнгарчууд, Дөрвөдүүд биш, Хошуудууд байжээ. Дараагийн бүлэгтээ дээрх санал бодлоо дурдаж, 17-р зууны үед ямар ямар үйл явдал болсон тухай бичнэ.

II. Улс төрийн өрсөлдөөн болон удирдагчдын өөрчлөлт

Мияваки Жүнкогийн өгүүлснээр, 17-р зууны үед Дөрвөн Ойрадын анхны удирдагч нь Дөрвөдийн Далай Тайш, дараагийнх нь Хошуудын Гүүш Хаан, гуравдугаарх нь Зүүнгарын Галдан Бошигт Хаан байжээ.¹⁵ Гэхдээ, сүүлийн үед Цэнгэл гэдэг Өвөр Монголын эрдэмтэн Миявакигийн үзэл бодлыг эсэргүүцэн бичиж байна. Цэнгэлийн үзэл санаагаар, Дөрвөн Ойрадын анхны удирдагч нь Дөрвөдийн Далай Тайшбиш, Хошуудын Байбагас Баатар байжээ.¹⁶ Би энд дурдсан Цэнгэлийн үзэл санааг дэмжиж, энэ өгүүлэлдээ хоёр баримтыг нэмж оруулна. Нэгд, *Зая Бандидын Намтар* нь Дөрвөдийн Далай Тайшийн амьдарч байсан 1615 оноос эхэлж байгаа боловч, Далай Тайшийг нэг ч удаа дурдахгүй байна. *Зая Бандидын Намтар* нь Дөрвөдийн Далай

¹³) Чиндай, р. 32; Намтар, fol. 18-a [р. 13].

¹⁴) Чиндай, р. 78 зүүлт 132.

¹⁵) Hidehiro Okada and Junko Miyawaki, "The Biography of Zaya Pandita," p. 36.

¹⁶) Khoshut Tsengel (Qinggeli), "The Formation of the Dörben Oyirad Alliance," *Eurasian Studies* vol. 1, ed. Yu Taishan and Li Jinxiu, Beijing: Shangwuyin Shuguan, 2011, pp. 256-261, pp. 264-265 зүүлт 43.

Тайшийн оронд Хошуудын Ноён Байбагас Баатарыг Дөрвөн Ойрадын тэргүүн хэмээн бичсэн байна (“*cecen xāni eḡige noyon Bayibaxas bātur terigüülen dörbön oyirodiyın noyod bügüidēr nijēd küböügēn bandi bol᠎oyo geji ama abulcaqsan-du*”).¹⁷

Зая Бандидын Төвдөөс Ойрадийн нутаг руу буцаж ирсэн 1639 оны орчимд Дөрвөн Ойрадын удирдагч нь “Ойрадын хоёр тайж (*oyirodoi xoyor tayiji*); өөр хэлбэл, Хошуудын Очирт Тайж болон Зүүнгарын Баатар Хун Тайж)” байжээ. Тийм учраас, Ойрадын энэ хоёр тайж нь Дөрвөн Ойрадын төлөөлөгчөөр 1640 оны Халх-Ойрадын Хуралд оролцсон байна.¹⁸ Гэхдээ, энэ хамтын удирдлага нь энэ үед нэг их тогтвортой байгаагүй. Яагаад гэвэл, Очирт Тайж ба Баатар Хун Тайж улс төрийн тэмцэл хийж байсан. Жишээ нь, Хошууд Очирт Тайж өөрийнхөө авга ах Хөндлөн Увшийг хэдэн удаа дайрсан бөгөөд Зүүнгар Баатар Хун Тайж өөртэй нь нэг овогтой гэвч ер нь Хөндлөн Увштай холбоотой байсан Дөрвөд хүмүүстэй байлдах ёстой болж байсан.¹⁹ Гэхдээ, Ойрадын хоёр тайж нь өрсөлдөгчдөө амжилттай ялаад, тэдний нутгийг эзлэн авсан.²⁰ Тийм болохоор, тус Ойрадын хоёр тайж Зүүнгарын Баатар Хун Тайжийг нас барах хүртэл Дөрвөн Ойрадыг үргэлжлүүлэн захирсаар байжээ.

Зүүнгарын Баатар Хун Тайжийг нас барсны дараа, Хошуудын Очирт Тайжид нэг шинэ өрсөлдөгч гарч ирсэн. Тэр хүн бол Очирт Тайжийн өөр ээжтэй хүү Авлай юм. Тэр үеэс Очирт Тайж Дөрвөн Ойрадын удирдагч болж, өөрийнхөө цол тушаалаа хамгаалахын тулд Авлайтай тэмцэлдэх хэрэгтэй болсон. Улс төрийн ийм нөхцөл байдалд, Зүүнгар хүмүүсийн дотор үе залгамжлах тэмцэл болж, Очирт Тайж Зүүнгарын зүүнгарыг дэмжиж, Авлай Зүүнгарын баруунгарт дэмжлэг үзүүлсэн. Гэхдээ, Зая Бандидын зүтгэл зохицуулалтын ачаар, энэ үед Очирт Тайж, Авлай хоёрын хооронд жинхэнэ дайн болоогүй.

1659 онд Сэнгэ холбоотонтойгоо цуг хамаг Зүүнгар хүмүүсийг дахиж нэгтгэснээс хойш, Очирт Тайж, Авлай хоёрын хооронд бүрэн хэмжээний дайн болж эхэлсэн. Тухайлвал, 1660 оны зун Очирт Тайж Зүүнгар Сэнгэтэй хамт Тарахай ба Хар Хужир гэдэг газар их хуралдай хийсэн.²¹ Тарахай болон Хар Хужир нь Авлайгийн гол нутаг байсан Эрчис мөрөнтэй их ойрхон учраас,²² энэ их хуралдай нь Авлайгийн хувьд их тулгаж сүрдүүлсэн үйл явдал болсон. Тийм болохоор, Зая Бандид тэдгээр хоёр хүчтэй тайж нарын хоорондох зөрчлийг дахин энх тайвнаар зохицуулахыг оролдсон боловч бүтээгүй. Яагаад гэвэл, Очирт Тайж 1660 оны өвөл Эрчис ба Зайсаны орчимд нутаглаж байсан Авлайг гэнэт дайрсан. Тэгээд, Авлай нь Балхаш, Зайсан нуур хоёрын хооронд байсан Алхуй гэдэг газар луу арай чарай зугтаад, өөрийнхөө цэрэг болон холбоотныг цуглуулсан. Энэ үед Авлай нь Очирт Тайжийн дайсан хэвээр байсан Хошуудын Хөндлөн Увшийн хөвгүүд болон Дөрвөдийн цэрэгтэй холбоо тогтоосон. Гэтэл, Очирт Тайж Зүүнгарын Сэнгэ ба Хойдын Солтон Тайштай холбоотон болсон. Тэдгээр хоёр бүлэг нь 1661 оны 4-р сард Эмил голын орчимд байлдсан.²³ Энэ дайны үр дүнд Очирт Тайж өөрийнхөө гол өрсөлдөгч Авлайг ялаад, Авлай болон түүний холбоотны

¹⁷⁾ Намтар, fol. 2-b [p. 3].

¹⁸⁾ Чиндай, pp. 5-6; Намтар, fol. 4-b [p. 4].

¹⁹⁾ Чиндай, p. 8; Намтар, fol. 6-a [p. 6].

²⁰⁾ Чиндай, p. 9; Намтар, fol. 7-a [p. 6].

²¹⁾ Чиндай, p. 34; Намтар, fol. 19-b [p. 14].

²²⁾ Renat map I, in John F. Baddeley, *Russia, Mongolia, China*, vol. 1, Martino Publishing, 2006.

²³⁾ Чиндай, pp. 35-36; Намтар, fol. 20-b – 21-a [pp. 14-15].

(Хөндлөн Увшийн хөвгүүд болон Дөрвөдүүд) хүчийг бүрэн сааруулсан.²⁴ Тэр үед Очирт Тайжид цэргийн тусламжийг үзүүлсэн Зүүнгар болон Хойдын ноёд бүгдээрээ Очирт Тайжийг өөрсдийнхөө удирдагчаар хүлээн зөвшөөрсөн учраас,²⁵ Очирт Тайж нь 1661 онд Дөрвөн Ойрадын улс төрийн удирдагч болсон.

Очирт Тайжийн энэхүү эрх мэдлийг нь 1666 онд Далай Лам дахин баталгаажуулсан. Өөрөөр хэлбэл, Далай Лам энэ онд Очирт Тайжид Очир Сэцэн Хаан гэсэн цол өргөмжилсөн.²⁶ Тэр үед Очирт Тайж Дөрвөн Ойрадын хувьд ганцаараа хууль ёсоор хаан ширээнд суусан. Үүний үр дүнд, Авлай Дөрвөн Ойрадын удирдагч болох боломжоо бүрмөсөн алдсан. Тэгээд тэр 1671 онд шинэ улс төрийн завшааныг эрж хайн Торгуудын газар нутаг руу гарсан. Гэхдээ, энэ удаа ч гэсэн Авлай болон түүний холбоотнууд нь Хошууд Очир Сэцэн Хаан ба Торгууд Аюкид ялагдсан.²⁷ Ийнхүү Очир Сэцэн Хааны хамгийн том улс төрийн өрсөлдөгч Авлайгийн эрх мэдэл нь бүрэн сүйрсэн.

Гэхдээ, харамсалтай нь, Очир Сэцэн Хаанд яг энэ үед нэг шинэ өрсөлдөгч гарч ирсэн. Тэр хүн бол Зүүнгарын Галдан юм. 1671 онд Дөрвөдийн Алдар Тайш нь Очир Сэцэн хааны талаас Галданы тийшээ зугтсан. Тэгээд 1673 онд Хошуудын Хөндлөн Увшийн хүү Данжин Хун Тайж ч Очир Сэцэн Хааны талаас Галданы бүлэг рүү явсан.²⁸ Үүнээс, урьд цагтаа Авлайгийн бүлэгт орж байсан хүмүүс нь Авлайгийн мөхлийн дараа шинээр ил гарч байгаа Галданы бүлэгт ороод, шинэ улс төрийн боломжийг эрж хайсныг мэдэж болно. Түүнээс гадна, их сонирхолтой нь, Галданы гол үндсэн нутаг Авлайгийн өмнөх нутагтай бараг адилхан байсан. Тийм учраас, тэр үед ихэнх Ойрад хүмүүс нь Галданг мөхсөн Авлайг орлож гарч ирлээ гэж бодож байсан бололтой.

Очирт Сэцэн Хаан өөрийнхөө шинэ өрсөлдөгч Галданг 1675 оны зун дайрсан. Гэвч тэрээр Галдангийн цэрэгт ноцтой ялагдаад, 1676 онд тэдэнд баригдсан. Тийм болохоор, Галдан одоо Очир Сэцэн хааныг орлоод, бүх Ойрад хүмүүсийн ганц удирдагч болсон. Үүнээс гадна, Далай Лам Галдангийн бүх Ойрад улсад тогтоосон эрх мэдлийг хүлээн зөвшөөрч Бошигт Хаан гэдэг цолыг түүнд өргөмжилсөн. 1671 онд Авлай мөхсөн бөгөөд 1676 онд Очирт Сэцэн Хаан мөхөн сүйрсэн болохоор, одоо Галдан Бошигт Хаанд ямар нэгэн хүчирхэг улс төрийн өрсөлдөгч байхгүй болжээ.

ДҮГНЭЛТ

Дөрвөн Ойрадын доторх улс төрийн өрсөлдөөнд Зүүн гар эцсийн ялалтыг байгуулсан нь үргэлжлэн явагдсан тэмцлийн үр дүн байсан. Гэхдээ, тус улс төрийн өрсөлдөөнд ихэнх цаг хугацааны туршид голдуу түрүүлж байсан бүлэг бол Хошуудууд байжээ. Зүүнгар нь тэр үеэр ер нь Хошуудын хамтарсан засаг захиргааны нөхөр эсвэл Хошуудуудыг туслах бүлэг байсан юм. Үнэндээ, Зүүнгарын удирдагч байсан Сэнгэ нь Очирт Тайжийг Авлайг ялахад асар том хувь нэмэр оруулсан юм. Гэхдээ, Хошууд Очир Сэцэн Хааны туслагчийн үүрэг гүйцэтгэсэн Зүүнгар Сэнгэг алагдсны дараа ийм нөхцөл байдал бүрэн өөрчлөгдсөн. Тухайвал, Төвдөөс буцаж ирсэн Галдан нь гэнэт Очир Сэцэн Хааны эсрэг бүлгийн бэлгэ тэмдэг болж, түүний эргэн тойронд Авлайгийн өмнөх

²⁴⁾ Чиндай, р. 38; Намтар, fol. 23-a [р. 16]; Чиндай, р. 43; Намтар, fol. 30-a [р. 20].

²⁵⁾ Чиндай, р. 37; Намтар, fol. 21-b [р. 15].

²⁶⁾ Чиндай, р. 44; Намтар, fol. 31-b [р. 21].

²⁷⁾ Чиндай, рр. 46-47; Намтар, fol. 34-a [р. 23].

²⁸⁾ Чиндай, р. 47; Намтар, fol. 34-b [р. 23].

бүлэгийнхэн байсан хүмүүс цугларсан. Өөрөөр хэлвэл, Галдан нь Очир Сэцэн Хааны шинэ өрсөлдөгч болж, өмнө нь мөхөсөн байсан Авлайг орлоод, Очир Сэцэн Хааны хүчийг сүйтгэсэн юм. Энэхүү Зүүнгар нь тэр үеийн улс төрийн хувьд хамгийн хүчтэй байсан Хошууд Очир Сэцэн Хааныг мөхөөсний дараа Дөрвөн Ойрадын улсуудын дунд, ялангуяа Хошуудын улсын дунд, ямар ч хүчтэй өрсөлдөгч үлдээгүй учраас, Дөрвөн Ойрадын удирдлагын төлөө тэмцэлд байнга тогтмол ялж байсан юм.

ABSTRACT

Power Struggle and Transition of Political Leadership among the Four Oyrads

This paper discussed the political geography of the four Oyrads and then the political power struggles which finally led to the transition of the leadership, from the Khoshuds to the Zunghars, among the Oyrads in the 17th century. Through the above examination, this paper, firstly, was able to prove the centrality of the Khoshuds among the four Oyrads in terms of physical as well as political geography. Secondly, by investigating the real process of power struggles in the lands of the Oyrads in the 17th century, this paper also concluded that the Zunghars came to emerge as a powerful nomadic empire as a result of the internal rivalry among the four Oyrad groups to acquire the leadership. In other words, the victory of the Zunghars was never an inevitable result that originated from its internal development but a kind of unexpected result of the continuous competitions having done by the political forgoers such as Ablai or Očirtu Čečen Khan of the Khoshuds. In addition, the final victory of the Zunghars was possible because there was no longer powerful political contender in the Khoshuds after the fall of the once very powerful Očirtu Čečen Khan.